



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЖИНСТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 06 сарын 07 өдөр

Дугаар A/73

Бодь

Хөдөө аж ахуйн ээлжит тооллого
зохион байгуулан тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, дэх заалт, аймгийн Засаг даргын 2022 оны А/294 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөдөө аж ахуйн ээлжит тооллогыг 2022 оны 06 дугаар сарын 20-ны өдрөөс 07 дугаар сарын 03–ны өдрийн хооронд зохион байгуулж явуулсугай.


2.Хөдөө аж ахуйн ээлжит тооллогыг сумын хэмжээнд зохион байгуулах ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

3.Хөдөө аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг айл өрх, аж ахуйн нэгжийг тооллогод бүрэн хамруулж ажиллахыг багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4.Тооллогын ажлыг хугацаанд нь чанартай зохион байгуулахыг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд үүрэг болгосугай.

5.Сумын Засаг даргын 2022 оны А/63 тоот захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.


ДАРГА



Р. БАТЖАРГАЛ

642201137

Сумын Засаг даргын 2022 оны 06 дугаар сарын 07
өдрийн А/Ж тоот захирамжийн хавсралт



Ажлын хэсгийн ахлагч

Н.Сумъяа

(Засаг даргын орлогч)

Гишүүдэд

Ж.Лхагвасүрэн

(Уубулан 1 дүгээр багийн Засаг дарга)

Д.Наранбаатар

(Хүйс 2 дугаар багийн Засаг дарга)

У.Батцэцэг

(Хөнөг 3 дугаар багийн Засаг дарга)

Б.Мөнхбат

(Цагаан ус 4 дүгээр багийн Засаг дарга)

Б.Ганцэцэг

(Бодь 5 дугаар багийн Засаг дарга)

Нарийн бичгийн дарга

П.Наранбаатар

(Санхүү албаны дарга)